



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/624

Арвайхээр

**Ажлын хэсэг байгуулж, журам
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "г" "ж", 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 40, 43 дугаар зүйл, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүн амын тоо, төвлөрөл, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээ, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан аймгийн төв Арвайхээр сум, аялал жуулчлалын бүс нутаг Хархорин сумын нутаг дэвсгэрт (зуны улиралд) хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг хоногийн 24 цагаар худалдаалах эрх олгох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт хоногийн 24 цагаар хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдах цагийн хуваарь тогтоосон шийдвэрийг боловсруулан батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Журмын дагуу иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч эрх олгох санал дүгнэлт гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Отгонцэцэг), журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга (О.Пүрэвдорж), Хархорин сумын Засаг дарга (Л.Энхбат), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат) аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн) -т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101191

Аймгийн Засаг даргын 2019 оны 10
дугаар сарын 08 -ны өдрийн 162 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч А.Отгонцэцэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүдэд О.Ганбат -Аймгийн Цагдаагийн газрын дарга
С.Дуламсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн
хяналтын газрын дарга
Г.Мөнхтөр -Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандартчлал,
хэмжил зүйн хэлтсийн дарга
Н.Дулам -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүнс, хөдөө аж
ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бодлого
төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
Ц.Төмөрбаатар -Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга Б.Анхбилэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны 10
дугаар сарын 08-ны өдрийн 7624 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

“24” ЦАГААР ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ЭРХ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн нутаг дэвсгэрт “24” цагаар ажиллах хүсэлт ирүүлсэн хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад эрх олгож, тэдгээрийн үйл ажиллагаанд нутгийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийж, хяналт тавихад энэхүү нийтлэг журмыг баримтална.

1.2. “24” цагаар худалдаа, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, худалдаа, үйлчилгээний салбарт мөрдөгдөж буй холбогдох дүрэм, журам, олон улсын болон үндэсний стандартын шаардлагыг нэгэн адил мөрдөхөөс гадна энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Хоёр. “24” цагаар худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

2.1. Удирдлага, зохион байгуулалт

2.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт энэхүү журмын хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх Ажлын хэсэг нь дээрх 24 цагаар ажиллах эрх олгох асуудлыг хариуцан зохион байгуулна.

2.2. Ажлын хэсгийн чиг үүрэг:

2.2.1. “24” цагаар худалдаа, үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын өргөдлийг холбогдох материалын хамт хүлээн авч, хянан ажлын 21 хоногийн дотор ажлын хэсгийн бүрэлдэхүүнээрээ хэлэлцэн, дүгнэлт гаргаж, эрх олгох эсэх талаар аймгийн Засаг дарга эцэслэн шийдвэр гаргах.

2.2.2. Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын материалыг хүлээн авч, ажлын хэсгийн хуралдаанаар гарсан дүгнэлтийг хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид журмын үндэслэлийн хамт хариу мэдэгдэх.

2.2.3. “24” цагаар ажиллах эрх олгохдоо сумдын нутаг дэвсгэр дэх хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын тоо, байршил зэргийг голлон анхаарах.

2.2.4. “24” цагаар худалдаа, үйлчилгээ эрхлэх хүсэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн хүлээн авч ажлын хэсгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг ханган ажиллана.

Гурав. “24” цагаар ажиллах худалдаа, үйлчилгээний байгууллагуудад тавигдах тусгай шаардлага

3.1. Зарим сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй доорх шалгуурыг хангасан худалдаа үйлчилгээний газруудад “24” цагаар хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ (худалдаа, үйлчилгээ гэх) эрхлэх эрхийг аймгийн Засаг даргын шийдвэрээр олгоно.

3.1.1. “24” цагаар ажиллах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага нь хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр тогтмол, төрөлжсөн үйл ажиллагаа явуулдаг, худалдаа, үйлчилгээний чиглэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрдөх тухайн чиглэлийн стандартын шаардлагыг хангасан байна.

3.1.2. “24” цагаар үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байр нь инженерийн төвлөрсөн буюу хэсгийн шугам сүлжээнд холбогдсон байх бөгөөд орчны болон фасадны зохих шаардлагыг хангасан гэрэлтүүлэгтэй, үйлчлүүлэгчдийн зорчих хэсэгт чанарын шаардлага хангасан явган хүний зам, авто зогсоолтой байна.

3.1.3. “24” цагаар ажиллах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж нь эрх бүхий байгууллагаас баталсан загвар зургийн дагуу хийгдсэн, нэг загвар бүхий гэрэлтүүлэг хаягтай байна.

3.1.4. “24” цагаар үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага нь гадна орчны тохижилтыг стандартын дагуу хийж, тодорхой хэсэгт ногоон байгууламжтай байна. Мөн дээрх аж ахуйн нэгж нь цагдаагийн болон гэрээт хамгаалалтын газартай гэрээ байгуулах, хяналтын камер, дохиоллын систем суурилуулах зэргээр аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.1.5. “24” цагаар ажиллах худалдаа, үйлчилгээний газрууд нь стандартын шаардлага хангасан гялгар уутнаас гадна хүнсний зориулалтын сав баглаа боодол, даавуун буюу цаасан уут торыг заавал хэрэглэж хэвшүүлсэн байна. Мөн ажил үйлчилгээндээ дуудлагаар болон захиалгаар үйлчлэх үйлчилгээ бусад төрлийн нэмэлт үйлчилгээг нэвтрүүлсэн байж болно.

3.1.6. Нийтийн орон сууц болон бусад худалдаа, үйлчилгээ явуулахыг хориглосон газар, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух худалдаа, үйлчилгээний газарт “24” цагаар үйл ажиллагаа эрхлэх эрх олгохгүй.

3.1.7. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд Хархорин сумын нутаг дэвсгэрийн амралт, зугаалгын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд 24 цагаар үйл ажиллагаа явуулах эрхийг сумын Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын дэргэдэх ажлын хэсгээр хэлэлцэн, аймгийн Засаг даргын шийдвэрээр олгоно.

3.1.8. “24” цагаар ажиллахаар зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллага нь тогтоосон цагийн хуваариар ажиллаагүй, хууль болон бусад журмаар хориглосон хязгаарлалтыг зөрчсөн зэрэг нь холбогдох байгууллагын хяналт, шалгалтаар тогтоогдсон тохиолдолд эрхийг цуцалж, дараагийн аж ахуйн нэгж, байгууллагад эрхийг олгоно.

3.1.9. “24” цагаар үйл ажиллагаа явуулах худалдаа, үйлчилгээний газруудын хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаа эрхлэх эрх олгосны дараа хамтран ажиллах гэрээг сумын Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3.1.10. “24” цагийн худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийг зөрчсөн, оршин суугчдаас үйлчилгээний талаар ноцтой санал гомдол ирж, тэрхүү гомдлын үндэслэл нотлогдсон тохиолдолд эрхийг хүчингүй болгоно. Зөрчлийн улмаас хүчингүй болгосон “24” цагийн эрхийг 1 жилийн хугацаанд дахин сэргээхгүй.

Дөрөв. Хориглох зүйл

4.1. Хадгалах хугацаа дууссан, чанарын баталгаагүй бараа бүтээгдэхүүн худалдаалахыг хориглоно.

4.2. Зөвшөөрөгдсөн цэгээс бусад нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ил задгай хүнсний болон барааны худалдаа (жимс, ногоо, шорлог, төрөл бүрийн машинт худалдаа, чингэлгийн худалдаа) эрхлэхийг хориглоно.

4.3. Худалдааны газарт тамхины төрөл бүрийн урамшуулалт худалдаа зохион байгуулахыг хориглоно.

4.4. Худалдааны газрууд 18-21 нас хүртэлх хүүхдэд тамхи, согтууруулах ундааг холбогдох журмын дагуу тогтоосон цагийн хуваариар худалдаалж, журмаар зөвшөөрөөгүй бусад бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхлэхийг хориглоно. Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн биеийн байцаалтыг үзэж болно.

4.5. “24” цагаар ажиллах хүнсний дэлгүүр, худалдааны төв, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний танхимд төлбөртэй тоглоом, барьцаалан зээлдүүлэх, эмийн сан (хүнсний дэлгүүрээс дээшх ангилалд хамаарахгүй), кино прокатын үйлчилгээ, хими цэвэрлэгээ, фото зураг угааж боловсруулах, хувцас захиалга, засвар, түлхүүр олшруулах чиглэлээр талбай түрээслэх, даралтад хийн зуух байрлуулан галлахыг хориглоно.

4.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор түлш, мод, нүүрс, бусад тэсэрч дэлбэрэх аюултай ахуйн болон үйлдэвэрлэлийн зориулалттай бараа бүтээгдэхүүнийг худалдаа үйлчилгээний газруудад “24” цагаар худалдаалахыг хориглоно.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1. Холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.